



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/15


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хүний хувийн мэдээлэл хамгааах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын "Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээлэл устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөн ажиллахыг газрын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэст (Т.Оюунтуул)-д тдаалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В. Оюумаа

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 08..... сарын 10.....ны
өдрийн 2025..... тушаалын хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАХ, МЭДЭЭЛЭЛ УСТГАХ,
МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Нийслэлийн өмчийн харилцааны газар /цаашид “Газар” гэх-/т хувь хүний болон мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор ажиллаж байгаа дурсний төхөөрөмж /камер/-өөр бичигдсэн видео мэдээллийг ашиглахад хязгаарлалт хийх, устгах, дүрсэнд бичигдсэн мэдээллийг эзнийг тодорхойлох боломжгүй болгох харилцааг зохицуулна.

1.2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэ журмыг боловсруулав.

1.3. Журмын хэрэгжилтэд Газрын дарга хяналт тавина.

**ХОЁР. Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, устгах, мэдээллийн эзнийг
тодорхойлох боломжгүй болгох**

2.1. Газрын даргаас бусад албан хаагчид болон иргэд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөнөөс бусад тохиолдолд камерын бичлэгийг шууд болон ухрааж үзэх, түүнтэй танилцах боломжгүй.

2.2. Газрын даргын зөвшөөрснөөр энэ талын мэргэжилтэн /программист, сүлжээний инженер/, гаднын бусад мэргэжлийн этгээд камерын бичлэгтэй танилцахад журмын 2.1 дэх хэсэгт заасан хамаarahгүй.

2.3. Мэдээллийн эзэн камерын бичлэгийн өөрт хамааралтай буюу эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах боломжтой гэж үзсэн хэсгийг хуулбарлан гаргуулах, бичиж авах тохиолдолд холбогдох мэргэжилтэн /программист, сүлжээний инженер/ тухайн бичлэгт байх гуравдагч этгээдийг танигдах боломжгүй болгоно.

2.4. Журмын 2.3 дахь хэсэгт заасан тохиолдолд тухайн дүрс бичлэг гуравдагч этгээдийг бичээгүй бол мэргэжилтэн /программист, сүлжээний инженер/ нэмэлт ажиллагаа хийх шаардлагагүй.

2.5. Шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагууд /ТЕГ, АТГ, ЦЕГ, Прокурорын байгууллага зэрэг/-ийн шаардсан хэлбэрээр камерын бичлэгийг гаргаж өгнө.

2.6. Энэ журам, холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд камерын бичлэгтэй хэн ч сайн дураар танилцах боломжгүй.

2.7. “Камерын дүрс бичлэг”-ийг устгахад санаатайгаар гар ажиллагаагаар гүйцэтгэхгүй ба мэдээлэл хадгалагдах хэмжээ дүүрсэн тохиолдолд “устах”, улмаар “бичих” гэсэн системийн автомат байдлыг ашиглана.

ГУРАВ. Бусад

3.1. Энэ журмыг зөрчиж камерын дурс бичлэгтэй танилцсан буюу танилцахаар оролдсон, түүнийг устгасан буюу устгахаар завдсан албан хаагчид Газрын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Журмын 2.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хамаарах зардлыг Газар хариуцна.

---оОо---